



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/153

Номгон

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын
газрын эзэмшлийн 800м2 газар эзэмших
эрхийн гэрчилгээг "Морьтон Чингис"
ХХК-д шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3, 11.2.5, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 202 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын Засаг даргын 2022 оны 01 дугаартай гэрээ, 2025 оны 20220422-01 дугаартай хамтран ажиллах сунгалтын гэрээ, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 3/438 дугаарт хамтран ажиллах хүсэлтийн дагуу сумын Засаг даргын Тамгын газрын эзэмшлийн Дуурсах 3-р баг, Хийморь-1 гудамжинд байрлах 6409010441 нэгж талбарын дугаар бүхий 800м2 газрыг нийтийн орон сууц барих зориулалтаар газар эзэмших эрхийг "Морьтон Чингис" ХХК-д шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Төр хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх нэгж талбарын үндсэн мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Эзэмшил газрын өөрчлөлтийг Газрын удирдлагын цахим системд бүртгэн цахим гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, түншлэлээр бий болсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 17/71 дүгээр тогтоол, сумын Засаг даргын 2025 оны 20220422-01 дүгээр гэрээнд заасны дагуу орон нутгийн өөрийн өмчид шилжүүлэх, бүртгэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Мөнхбат),Орон нутгийн өмчийн газар (З.Мөнхтөр) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Эзэмшил газрыг зориулалтын дагуу эзэмшиж, гэрээний үүргээ биелүүлж ажиллахыг "Морьтон Чингис" ХХК-д үүрэг болгосугай.

626010407

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ



Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 1/153 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Газар эзэмших эрхээ шилжүүлж буй иргэний мэдээлэл										Газар эзэмших эрхээ шилжүүлэн авч буй иргэний мэдээлэл				
№	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Нэгж талбарын хаяг	Газрын хэмжээ м2	Газрын этгээдийн нэр	Регистрийн дугаар	Газрын эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ м2	Нэгж талбарын хаяг	Газар ашиглалтын зориулалт	Газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа	
1		2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Сумын Засаг даргын Тамгын газар	9007377	6409010441	Баянхонгор сум, Дуурсах 3-р баг, Хиймөр-1 гудамж, 121 тоот	800	"Морьтон чингис" ХХК	6320392	Эзэмших	6409010441	800	Баянхонгор сум, Дуурсах 3-р баг, Хиймөр-1 гудамж, 121 тоот	5-8 давхар нийтийн орон сууц	12 жил	